

**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-24
1. Ядуурал, зохистой хөдөлмөрийн зорилгын хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээллийг сонсох	3-24

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны
06 дугаар сарын 10-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны дарга Б.Мөнхсоёл ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 26 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: М.Энхцэцэг;

Тасалсан: П.Батчимэг.

**Нэг.Ядуурал, зохистой хөдөлмөрийн зорилгын хэрэгжилтийн талаар
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээллийг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга Х.Тамир, мөн газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга Ю.Отгонбилэг, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга Ц.Баярмаа, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнсүх, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Б.Хонгорзул, Үндэсний статистикийн хорооны Нийгмийн статистикийн газрын дарга М.Оюунцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн байлцав.

Ядуурал, зохистой хөдөлмөрийн зорилгын хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, О.Батнайрамдал, М.Мандхай, М.Бадамсүрэн, Б.Мөнхсоёл нарын тавьсан асуултад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Б.Мөнхсоёл нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Ядуурал, зохистой хөдөлмөрийн зорилгын хэрэгжилтийн талаарх Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 12 минут үргэлжилж, 10 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 38 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ЗОРИЛГЫН ДЭД ХОРООНЫ
ДАРГА

Б.МӨНХСОЁЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим, 12 цаг 26 минут

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Мөнхсоёл: Дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн ирцдээ орчихсон байна. Отгоншарын Батнайрамдал, Энхбаярын Батшугар, Батбаярын Жаргалан, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Агваанлуvsангийн Ундраа. Тэгэхээр гишүүдийнхээ амгаланг айлтгаад, хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулчихлаа. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, дэд хорооны ирц 70 хувьтай бүрдсэн тул Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх 1 асуудал байгаа. Ядуурал, зохистой хөдөлмөрийн зорилгын хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээллийг сонсох. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасныг үндэслэн Ядуурал, зохистой хөдөлмөрийн зорилгын хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээллийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан таныг мэдээллээ танилцуулахыг урьж байна. Сайдын микрофоныг нээнэ үү. Ажлын хэсгийг танилцуулах уу.

Л.Энх-Амгалан: Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ингээд Тогтвортой хөгжлийн зорилгын 1 дүгээр зорилт болох ядуурлын устгах зорилтын хүрээнд нийт 7 зорилтыг дэвшүүлж, 14 үзүүлэлтээр өнөөдөр хэмжиж байгаа.

Зорилт 1.1. 2030 он гэхэд өдөрт 1 доллар 25 центээс бага орлоготой гэж одоогоор тооцогдож буй хүмүүсийн туйлын ядуурлыг арилгах хүрээнд хийгдэж байгаа ажлуудын талаар бас мэдээлэл өгье.

Ядуурлын түвшнийг олон улсын болон үндэсний хэмжээнд ингээд 2 янзаар тодорхойлж байгаа. Олон улсын түвшинд 1 хүний өдрийн хэрэглээ нь 2 доллар 15 центээс бага орлоготой /бага орлоготой орнуудын хувьд/ дунд орлоготой орнуудын

хувьд өдөрт 3 доллар 65 цент, өндөр орлоготой орнуудын хувьд өдөрт 6 доллар 85 центээс доогуур байгаа өдрийн хэрэглээ нь доогуур байгаа хүмүүсийг бол туйлын ядууралд тооцдог. Монгол Улсын хувьд 2022 оны байдлаар дундаж орлоготой улсын тоонд багтаж байгаа бөгөөд Дэлхийн банкнаас хийсэн тооцооллоор өдөрт 3 доллар 65 центээс бага орлоготой хүн амын эзэлж байгаа хувь нь 2,4 байна гэсэн ийм юу гарсан байна.

Зорилт 1.2. 2030 он гэхэд үндэсний тодорхойлолтын дагуу ядуурлын бүх хэмжигдэхүүнээр ядуу амьдарч байгаа бүх насны эрэгтэй, эмэгтэй болон насны онцлогийг яаж хүүхдийн ядуурал гэх мэтчилэнээр хувийн жинг наад зах нь 2 дахин бууруулах ийм томоохон зорилт тавьсан. Үндэсний хэмжээнд ядуурлыг тооцохдоо ядуурлын шугамаас доогуур амьдарч байгаа хүн амын эзлэх хувиар буюу орлого хэрэглээн дээр үндэслэн Үндэсний статистикийн хорооноос өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг 2 жил тутам хийж, ядуурлын дүр төрхийн тайланг гаргаж байгаа. 2 жил тутам.

Тэгэхээр өнөөдрийн та бүхэнд өгч байгаа тоо бол 2022 оны тоо гэж ойлгож болно. 2022, 2023 оны тоо. Ингээд Монгол Улсын ядуурлын түвшин 2022 онд 27,1 хувь буюу 913 мянган хүн ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй амьдарч байна. Хөдөө, орон нутгийн хүн амын 35,5 хувь нь ядуурлын шугамаас бага хэрэглээтэй байгаа бол хот суурин газарт 23 хувьтай байна. Үндэсний ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь 27,2 хувь, эрэгтэйчүүдийн эзлэх хувь 27,2, Хүн амын насны бүлгээр авч үзвэл 0-18 насны хүүхэд 32 хувь, 60-аас дээш насны бүлэг бол 18,4 хувь нь ядууралд байна гэсэн ийм тооцоо байгаа.

Хүний хөгжлийн тайланд 2010 оноос эхлэн олон хэмжээст ядуурлын тайланг гаргаж эхэлсэн. Монгол Улс олон хэмжээст энэ ядуурлын тооцоонд ашигласан хамгийн сүүлийн олон нийтэд ил болгосон судалгааны өгөгдөл нь 2018 оны тооцооллоор байгаа бөгөөд энэ тооцооллын дагуу Монгол Улсын хүн амын 7,3% хувь буюу 2021 онд 243 мянган олон хэмжигдэхүүнд ядууралд өртсөн байна гэж харж байгаа юм.

Тэгэхээр энэ олон хэмжээст ядуурал гэдгийг бид нар юу гэж ойлгох вэ гэхээр дэлхийн улс орон 40 гаруй улс орнууд үндсэндээ энэ ядуурал яг ийм олон хэмжээсээр хэмждэг ийм тогтолцоонд шилжиж байгаа юм байна лээ. Манай улс энийг 2018 оноос эхэлж хэрэглэж байгаа. Гэхдээ яг эцэслэж бид нар яг олон хэмжээст ядуурлыг яг ямар хэмжээсээр хэмжих вэ. Аргачлалыг нь яаж эцэслэх вэ гэдэг дээр манай яам, Статистикийн ерөнхий газартай газартай бас хамтарч холбогдох Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам гэх мэтчилнээр холбогдох яамнуудын ажлын хэсгүүд гарч ажиллаж байгаа. Ингээд бид нар ер нь цаашдаа энэ олон хэмжээст ядуурлын үзүүлэлтүүдээр ядуурлаа хэмждэг болох ёстой гэж ойлгож байгаа. Тэгэхгүй бол олон жил бид нар чинь бараг сүүлийн 30 жил л 1 ийм ядуурлыг 27-30 хувьтай зарладаг. Ингээд 3 хүний 1 нь ядуу амьдардаг гэсэн ийм л тоог яамнууд нь зарладаг, улс төрчид нь хэлдэг, төсөв мөнгөний бодлого нь нэг ийм хэмжээнд л батлагдаж гардаг ийм тогтолцоотой болсон байна. Тийм учраас цаашдаа бид нар энэ ядуурлын тухай ойлголтуудаа цэгцлэх ёстой юм байна. Ядуурлын үзүүлэлтүүд, хэмжиж байгаа үзүүлэлтүүдээ бас тодорхой цэгцлэх ёстой юм байна. Тэр тусмаа өнөөдөр яг хүн амын аль хэсэг нь өнөөдөр энэ ядууралд өртөөд байна вэ. Ядуурлын эмзэг бүлэгт хамрагдаад байна вэ. Энэ рүү чиглэсэн бодлогынхоо арга хэмжээнүүдийг яаж авах вэ гэдэг дээр их тийм цэгцтэй бодлого

хийх ёстой гэж ойлгож байгаа. Энэ хүрээнд манай яам, Үндэсний статистикийн ерөнхий газартай хамтарч үндэсний хэмжээний их өгөгдлийн платформуудыг боловсруулж байна. Ингээд үндэсний их өгөгдлийн платформ бий болж чадах юм бол бид нар ядуурлын жинхэнэ утгаар нь хэмжих, сумын хэмжээнд, аймгийн хэмжээнд, дүүргийн хэмжээнд хэмжиж, өнөөдөр энэ ядууралд өртөөд байгаа тэр 940 мянган нөхдүүд маань хаана, яг юу хийж, ядуу гэдэг ангилал дээр яагаад байгаад байгаа юм. Яагаад энэ хөдөлдөггүй юм гэдэг зүйлүүдийг зөв хэмжих, зөв оношлох ийм бололцоонууд бид нарын өмнө гарна гэдгийг бас хэлье гэж бодож байна.

Зорилт 1.3. Үндэсний онцлогт тохирсон нийгмийн хамгааллын тогтолцоо, бүх хүнд зориулсан нийгмийн хамгааллын арга хэмжээ, түүн дотор нийгмийн хамгааллын үндсэн үйлчилгээг нэвтрүүлж, түүнд ядуу эмзэг бүлгийн дийлэнх хэсгийг 2030 онд хамруулна гэсэн бас ийм зорилт байгаа. Энэ зорилтыг хэмжихэд нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамрагдаж байгаа хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажилгүйчүүд, жирэмсэн эх, ахмад настныг тухайн бүлгийн хүн амд харьцуулж тооцдог. Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийг бид нар Улсын Их Хуралд өргөн барихаар ингээд бэлэн боллоо. Сая Засгийн газраар хэлэлцэгдсэн. Ингээд энэ хуулиар бас тодорхой томоохон нийгмийн хамгааллын тогтолцооны шинэчлэлүүд хийгдэнэ.

2023 онд батлагдсан Нийгмийн даатгалын багц хуулиар бол тодорхой ийм шинэчлэлүүдийг хийсэн. Энэ хүрээнд бол тэтгэврийн хэмжээ нь хэмжээг жил бүр инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлдэг болсон. Энэ бол энэ жилээс хэрэгжиж эхэлж байгаа. Тэтгэврийн зөрүүг үүсгэхгүй байх зорилгоор цалин хөлсөнд хэрэглэх итгэлцүүрийг бас жил бүхэн шинэчлэн тогтоодог болсон. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч нас барвал түүний олон жил хамт амьдарсан эхнэр, нөхрийн тэтгэврийн хэмжээг хүртэл хувиар нэмэгдүүлэх ийм боломжуудыг бас энэ хуулиар бий болгосон. Ажлын байраа хадгалсан, хуулиар үүрэг хүлээсэн, хүлээсэн үүргээ биелүүлсэн ажил олгогчдод үзүүлэх шимтгэлийн хөнгөлөлтийн хэмжээг нэмэх, ажил олгогчдод үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийг ажлын байрнаас хамааран ялгаад төлөх, илүү ажилласан жил тутам тэтгэвэр бодох хувийг нэмэгдүүлэх зэрэг даатгуулагчийн эрх ашгийг хамгаалсан олон арга хэмжээг бас хуульчилсан. Одоогийн бид нарын Улсын Их Хуралд өргөн барих гэж байгаа хуулиар ч гэсэн бас энэ нэлээн олон ийм боломжуудыг бий болгохоор ингээд ажиллаж байна.

Ингээд тодорхой статистикуудыг би дурдахаа больё гэж бодож байна. Яагаад гэвэл энэ статистикууд та бүхэнд хүргэгдсэн байж байгаа.

Ер нь энэ Монгол Улсын нийгмийн халамжийн тогтолцоонд тулгамдаж байгаа гол асуудлын нэг бол энэ халамжийн хамрах хүрээ хэт өргөн, ядуу, зорилтот бүлэгтээ чиглэгдэж чадаагүй явдал гэж харж байгаа. Өнөөдөр улсын төсвөөс халамжийн зардал дээр 2,2-2,4 их наядыг баталж өгдөг. Яг энүүгээрээ халамжид нийт ДНБ-д эзэлж байгаа хувь, улсын төсвийн урсгал зардлын эзэлж байгаа хувиар бол их өндөр хувь гараад байдаг. Гэтэл энэ 2,2-2,4 их наядын чинь бараг үндсэндээ 1,7 их наяд нь хүүхдийн мөнгө байгаад байгаа юм. Хүүхдийн мөнгө. Яг өнөөдөр нөгөө эмзэг хэсэг буюу халамж хүртэх ёстой энэ хэсгийнх нь зарж байгаа 600-700 тэрбум төгрөгийн зардал маань өнөөдөр яг бодитойгоор тэр зорилтот бүлгүүддээ хүрч чадаж байна уу гэдэг асуудал дээр л бид нар их сайн тооцоолоод

хийх ёстой юм байна. Ингэж байж бид нар бодлогоо их зөв болгох ёстой юм байна гэж бодож байгаа.

Ингээд нийт халамжийн нийт зардлын 55 орчим хувь нь хүн амын хамгийн бага амьжиргаатай доод 40 хувьд хүрч байна. Харин халамжийн зардлын 26 хувь нь хүн амын хамгийн амьжиргаа сайтай, орлого өндөртэй 40 хувьд зарцуулагдаж байна гэж байгаа. Эндээс бид нар юу гэж ойлгож байна вэ гэхээр яг нөгөө халамж хүртэх гээд байгаа хүндээ бид нар халамж өгч чадахгүй байна. Халамжийг бид нар хавтгайруулсан учраас өнөөдөр хамгийн өндөр орлоготой иргэд маань хүртэл халамж хүртдэг ийм тогтолцоог бид нар бий болгочихсон байна гэдгийг ойлгох ёстой. Ингээд бид нар энэ халамжийн хуулиа бас Улсын Их Хуралд өргөн барихаар бэлтгэгдэж байна. Энэ Халамжийн хууль батлагдаж гарснаар Монгол Улсад ингээд халамж гэж байх юм бол халамжийн ямар тогтолцоо байх юм. Халамжийг хэн хүртэх юм. Ямар нөхцөлтэй байх юм. Насан туршдаа халамж хүртэх үү, хүртэхгүй юу. Халамжаас, хөдөлмөр эрхлэлтэд яаж шилжүүлэх вэ гэдэг бас ийм бодлогын арга хэмжээнүүдийг бас хийнэ. Энэ ташрамд бас энэ Дэд хороо дээр манай Улсын Их Хурлын яг энэ чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа гишүүд байгаа учраас маргааш, нөгөөдөр бид нар ордонд Тус солион гэж компанитай хамтарсан Монгол Улсын нийгмийн халамж, нийгмийн хамгааллын тогтолцооны зураглалуудыг бид нар хийлгэсэн. Системийн шинжилгээг бид нар хийлгэсэн. Ингээд энэ хийлгэсэн зураглал, системийн шинжилгээ дээр үндэслэж, 8 хуулиа өргөн барьж байгаа. Энэ бол Нийгмийн даатгалын багц хууль, Халамжийн хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Гэр бүлийн хууль, Гэр бүлийг дэмжих тухай хууль, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тухай хууль гэх мэтчилнээр яг ийм тогтолцооны шинэчлэлийн эрх зүйн актуудыг бид нар бэлэн болгосон. Өнгөрсөн 10 сард хийсэн манай яамны ажил гэж харж байгаа. Энэ 8 хуулиа батлагдаж гарч чадах юм бол Монгол Улсын нийгмийн хамгаалал болон нийгмийн халамжийн тогтолцоонд өнгөрсөн хугацаанд байсан энэ тогтолцооны алдааг бид нар засах ийм эрх зүйн шинэчлэлүүдийг хийхээр бас бэлдэж байгаа гэдгийг бас энэ чиглэлд хэлье гэж бодож байна.

Зохистой хөдөлмөр эрхлэлт гэдэг ойлголтыг бид нар нэг мөр болгож ойлгох ёстой юм байна гэж харж байгаа. Ер нь бол манай хөдөлмөрийн зах зээлийн бодлого, хөдөлмөр эрхлэлтийн бодлогууд яг хөдөлмөрийн зах зээлээсээ нэлээн гажуудсан ийм тогтолцоо байгаад байгаа. Тийм учраас цаашдаа бид нар энэ актив, леба маркет полици гэж ярьдаг юм байна лээ. Энэ дэлхийн улс орнууд хөгжиж байгаа улс орнуудын хэрэгжүүлж байгаа хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого буюу зохистой хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байр гэдэг энэ ойлголтуудыг бид нар бий болгох ёстой гэж харж байгаа. Энэ хүрээнд өнгөрсөн хугацаанд бид нар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, манай хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа өнөөдрийн дэмжиж байгаа энэ тогтолцоо бол цаг үеэсээ хоцорсон ийм тогтолцоо байгаа. Бид нарын саяын системийн анализыг хийж үзэхэд бол манай Хөдөлмөр, халамжийн байгууллагуудын бараг үндсэндээ 70-80 хувь нь дандаа захиргааны чиглэлийн ажил хийдэг хүмүүс болчихсон байна. Захиргааны чиглэлийн ажлууд.

Гэтэл яг жинхэнэ утгаар нь нөгөө ядууралтайгаа тэмцэх яг нөгөө хөдөлмөр эрхлэлт рүүгээ тэр бодлогуудыг хийх, тэр үйлчилгээг хийх хүмүүс нь 20-30 хувьд хүрсэн байна. Гурвалжин бол эргэсэн байна. Тийм учраас эргэсэн энэ гурвалжныг бид нар буцааж эргүүлэх ёстой. Ингээд хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцооны шинэчлэлүүдийн их зайлшгүй шаардлага байгаа

гэж бид нар харж байгаа. Тэгээд энэ хүрээндээ өнгөрсөн хугацаанд бид нар энэ Job center гэж дэлхийн улс орнуудад байдаг кэйс менежмент дээр үндэслэсэн, суурилсан яг тухайн хөдөлмөр хайж байгаа иргэдэд яг ямар ажлын байр дээр зохистой ажлын байр дээр яаж холбож өгөх юм, яг ямар ур чадваруудыг бий болгох юм гэдэг энэ чиглэл рүү тодорхой жинхэнэ утгаар нь ийм зохицуулалтууд хийдэг Job center үйлчилгээг Улаанбаатар хотын хэмжээнд 6 үйлчилгээг бид нар шинээр бий болгосон. Та бүгдийн нүдэнд бас харагдаж байгаа болов уу гэж бодож байна. Энийг бид нар цаашдаа бас сүлжээ болгож үндэсний хэмжээнд энэ энэ жил нийт 30 Job center үйлчилгээг үндэсний хэмжээнд нэвтрүүлэхээр ингэж ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

Б.Мөнхсоёл: Танилцуулга хийсэнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Тамир тус яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга, Энхболд Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын дарга, тус яамны Хөдөлмөрийн бодлогын газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга Отгонбилэг. Баярмаа тус яамны Хөдөлмөрийн бодлогын газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, Эдийн засаг, хөгжлийн яамнаас Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мөнгөнсүх тус яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хонгорзул тус яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн. Үндэсний статистикийн хорооноос Оюунцэцэг Үндэсний статистикийн хорооны Нийгмийн статистикийн газрын дарга. Цэрэнханд Тогтвортой хөгжлийн төлөө иргэний нийгмийн байгууллагын сүлжээний дэд зохицуулагч.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Батнайрамдал бас асууна гэсэн. Соронзонболд гишүүн. Батнайрамдал гишүүний нэрийг нэмнэ. Соронзонболд гишүүнээс эхэлье.

Л.Соронзонболд: Бүгдэд нь өдрийн мэндийг хүргэе. Энэ хүүхдийн мөнгийг яг зорилтот бүлгийн хүүхдүүдэд хүргэхээр, дээрээс нь тэр олон хүүхэдтэй айлуудыг бас бага орлоготой өрхийг ядуурлын түвшинд хүргэхгүй байхаар тооцсон манай хүүхдийн мөнгөний хэмжээ хэд юм бэ. Одоо бол жилдээ 1,5 их наяд төгрөгийг зарцуулдаг юм байна. Тэгэхээр хэрвээ бид нар яг зорилтот бүлгийн хүүхдүүдэд энэ мөнгийг зарцуулдаг болъё гэвэл хэдэн төгрөгийн асуудал яригдаж байна вэ гээд 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт болохоор бол бага орлоготой өрхийн насанд хүрэгчдийг хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулж байгаа гээд юу гарсан байна. 1200 гаруй өрхийг энэ дээр бол 80 хувь нь илүү ахицтай гарсан гээд. Тэгэхээр энэ ахиц гарсан гэдэг нь ямар үзүүлэлтээр тооцоод байна вэ гэж. Тэгээд энэ сургалтад хамрагдаад ур чадвар эзэмшээд ажилд орсон хүн нь хэд байдаг юм ч гэдэг юм уу иймэрхүү судалгаа байдаг юм уу гэж асуумаар байна.

3 дугаарт болохоор бол бага орлоготой өрхийг хэдэн нийгмийн ажилтанд, 1 нийгмийн ажилтанд хэдэн бага орлоготой өрх хамрагддаг юм бэ. Тэгээд тухайн ажилчдын маань ажлын гүйцэтгэлийн үнэлгээ нь тухайн бага орлоготой өрхийн

хувьд гарч байгаа ахиц дэвшлийг нь яаж, ямар үзүүлэлтүүдээр тооцож байна вэ гэдэг ийм асуулт байна.

Б.Мөнхсоёл: Сайдын микрофоныг өгье.

Л.Энх-Амгалан: Бид нар энэ хүүхдийн мөнгөний асуудлыг ер нь сайн ярих ёстой юм байна гэж харж байгаа. Энэ өмнө нь бас ковидын үед хүртэл ингэж 20 мянга байж байгаад ковидын үеэр 100 мянга болгоод, тэрнээс хойш л энэ ч уг нь ковидын үеийн дэмжлэг гэж гарч ирсэн шүү дээ. Тэгээд энэ дээр хүүхдийн мөнгөн дээр бид нар нэлээн мэдээж эмзэг сэдэв. Гэхдээ энэ дээр бас тооцоо судалгаа хийж, яг энийг зорилтот бүлэгт нь хүргэх энэ чиглэл рүү бас би бодлогын алхмууд хийгдэх ёстой л гэж ойлгож байгаа. Бид нар жил бүхэн 1,7 их наяд буюу 300-400мвт-тай тэнцэх цахилгаан станцын мөнгийг л хүүхдийн мөнгөнд өрхийн орлогоос үл шалтгаалаад л хавтгайраад тараагаад байна л гэсэн үг байхгүй юу.

Тэгэхээр цаашдаа ганцхан хүүхдийн мөнгө ч биш ерөөсөө халамж нэрийн доор, халамжийн хуулийн нэрийн доор хэрэгжүүлж байгаа нийгмийн хамгааллын, нийгмийн халамжийн бодлого хөтөлбөрүүд дээрээ нэг үнэлэлт дүгнэлт хийх ёстой гэж ойлгож байгаа. Манай яам хийсэн. Тэгэхээр би түрүүний танд хэлж байгаа, та бүхэнд хэлж байгаа тооцоо бол өнөөдөр яг энэ нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийг хүртэж байгаа хүмүүсийн бараг үндсэндээ 27 хувь, 30 хувь гээд хэлчихье. 3 хүний 1 нь бол өндөр орлоготой иргэдэд л энэ халамжийн мөнгөнүүд очоод байна гэсэн ийм тооцооллууд гарч ирж байгаа байхгүй юу. Тийм учраас бид нар мэдээж тогтолцооны шинэчлэлийн хувьд хүүхдийн мөнгө, одонтой ээжүүд, тэгээд насны хишиг энэ тэр гээд яг өрхийн орлогоос үл шалтгаалсан, хавтгайруулсан нөгөө 77 нэр төрлийн халамж гэж бид нар ярьдаг. Энэ бол 77 бас биш юм байна лээ. Цаг тулбал. Бид нар ангилж үзэхэд 40 орчим болж байгаа. Энийг л бид нар цаашдаа нэлээн цэгцлэх, яг тэр зорилтот бүлэг рүү нь, хүн ам руу нь чиглүүлсэн ийм бодлого хэрэгжүүлэх нь зайлшгүй шаардлага байгаа гэж харж байгаа.

Урьд нь бол хүүхдийн мөнгөн дээр бид нар бас тооцоо хийж байсан. Энийг Мөнхзул дарга хэлчихвэл дээр байх. Манай яаман дээр урд нь хийж байсан тооцооллууд, нөгөө зорилтот бүлэг рүүгээ чиглүүлбэл ийм ийм тооцооллууд байсан гээд. Бид нар чинь хэдэн онд билээ Улсын Их Хурал дээр өргөн бариад, тэгээд буцчихсан шүү дээ. 1 дэх асуудал.

2 дахь асуудал бол энэ төгсөлтийн аргачлал гээд Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлсэн маш их тийм сайн төсөл байгаа юм. Энэ бол хүнсний талон авдаг Соронзонболд гишүүн ээ, хүнсний талон авдаг байсан иргэн, өрхүүдийг бид нар сонгож, 1200 орчим иргэн, өрхүүдийг сонгож, энэ хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн юм. Энэ хөтөлбөр бол зөвхөн мөнгөн тусламж өгөөгүй. Яг тухайн хүнсний талон авч байгаа иргэд, хөдөлмөрлөх чадвартай иргэдийг сонгоод, тухайн ур чадварын сургалтуудыг хийгээд, тэгээд өөрийнх нь жижиг бизнесийнх нь өрхийн бизнес эрхлэхэд нь тоног төхөөрөмжүүд, санхүүгийн дэмжлэгүүд өгөөд дундын бас ийм хуримтлалын бүлгүүд гаргаж ирсэн. Маш сайн амжилтад хүрсэн хөтөлбөр байгаа юм. Тэгэхээр энийг хэмжиж байгаа хэмжүүр нь юу байна вэ гэхээр 1200 орчим иргэд хүнсний талон авч байсан иргэд хүнсний талон авахаа больсон л гэсэн үг. Өөрсдөө өрхийнхөө орлогыг бүрдүүлдэг болсон. Бүлгээр ажилладаг болсон. Өрхийн үйлдвэрлэлүүд хийдэг болсон. Та бүхэн санаж байгаа бол өнгөрсөн сард манай Чингис хааны талбай дээр яг энэ 1200 өрхийн хийж байгаа үйлдвэрлэлийн

чиглэлээр бас үзэсгэлэн худалдаа гарч, энэ хүмүүс бас тодорхой туршлагаасаа хуваалцсан. Энийг бол цаашдаа маш их тийм үр дүнд хүрсэн, Монголын хөрсөн дээр буусан ийм хөтөлбөр учраас бол цаашдаа нэлээн өргөтгөө. Сум, аймгийн түвшинд, бүсийн түвшинд бас энэ хөтөлбөрүүдээ өргөжүүлбэ гэсэн ийм бодолтой байна.

Яг нөгөө халамж хүртэж байгаа хүмүүс дээр 1 нийгмийн ажилтан дээр хэдэн өрх, хэдэн хүн хариуцаж ноогдож ажиллаж байна вэ гэдэг дээр бас Төрийн нарийн бичгийн дарга нэмээд хэлчих үү.

Б.Мөнхсоёл: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофоныг нээнэ үү. Манхай гишүүний бас нэрийг оруулчих. Асуулт асууна.

Л.Мөнхзул: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Хүүхдийн мөнгийг Монгол Улсын Засгийн газраас 2003 оноос хойш хамгийн анх нэвтрүүлж байсан. Анх 3000 төгрөгийг хүүхэд болгонд өгсөн. Дараа нь зорилтот бүлэг гэх гэх мэт хүүхдийн мөнгийг өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд хэрэгжүүлж ирэхдээ ихэвчлэн нийтлэг байдлаар олгож ирсэн. 2016 онд нийт хүүхдийн 80 хувьд нь хүүхдийн мөнгийг олгож байсан. Тухайн үедээ орлогыг орлуулан тооцох аргачлал дээр үндэслэн судалгаа хийгээд, хамгийн өндөр орлоготой 20 хувьд ноогдох өрхийн хүүхдүүдэд хүүхдийн мөнгө олгоггүй, нийт өрхийн 80 хувьд нь өгч байсан. Дараа нь 2017 онд бол нийт хүүхдийн 60 хувьд олгож байсан. Ингээд 2017 оны сүүл 2018 оноос эхлээд Монгол Улсын нийт хүүхдэд олгосон. 2023 онд нийт хүүхдийн 91 хувьд хүүхдийн мөнгө олгох бас зорилгоор ийм бодлогын өөрчлөлт хийгээд, тэгээд аргачлалтай холбогдолтой гомдлууд гарч ирсэн учраас нийт хүүхдийн 100 хувьд болгож өөрчилсөн байгаа. Манай яамнаас НҮБ-ын Хүүхдийн сантай хамтраад, ер нь Монгол Улсад 1 хүүхдийг өсгөхөд ямар хэмжээний зардал гардаг юм бэ гэдэг ийм өртгийн судалгаа бас олон улсын мэргэжилтэнтэй хамтарч хийхээр төлөвлөөд ингээд хийж байгаа.

Нөгөө талаасаа яг ингээд тооцооллыг нь ингээд аваад үзэхээр нийт хүүхдийн доор хаяж 60 хувьд нь хүүхдийн мөнгө очих нь зүйтэй юм гэсэн ийм зөвлөмжүүд бол байдаг. Нийт хүүхдийн доор хаяж 60 хувьд нь. Нөгөө талаасаа нийт хүүхдийн мөнгөнд олгогдож байгаа мөнгөн тусламжийн 30 орчим хувь нь банкны хадгаламжид бас хадгалуулдаг гэсэн бас ийм тооцоо судалгаанууд байдаг. Тэгэхээр яг 1 хүүхэд өсгөх зардлын хэмжээг тодорхой тооцоолж ер нь Монгол Улс гаргаж байгаагүй. Одоо анх удаа гаргахаар манай яам төлөвлөж ажиллаж байгаа. Энэ зардлыг гарсны дараа өрхөд ноогдох хүүхдийн тоотой харьцуулж уг мөнгөн дүнг бас нийт хүүхдийн хэдэн хувь нь хамрагдах нь зохистой вэ гэдгийг тодорхойлох нь илүү оновчтой гэж үзэж байгаа. Нөгөө талаасаа хүүхдийн мөнгө маань зөвхөн амьжиргааны зардал уу, аль эсвэл хөгжлийн төлөө хөрөнгө оруулалт уу гэдэг маргаантай байдаг учраас Монгол Улсын хувьд бол хүүхдийн хөгжилд зориулсан хөрөнгө гэж үзэж, нийт хүүхдэд олгож явдаг. Энэ чиглэлийг бас НҮБ-аас бас их илүү дэмжиж сайшаадаг ийм үзүүлэлт байгаа.

Монгол Улсын хэмжээнд сум болгонд бас хороо болгонд 1 нийгмийн ажилтан байна. Хэт төвлөрсөн хороодод 2 нийгмийн ажилтан байгаа. 10 мянгаас дээш хүн амтай зарим сумдад 10 мянгаас дээш хүн амтай бол 2 нийгмийн ажилтан байгаа. Үндсэндээ бол 560 орчим нийгмийн ажилтан ажиллаж байна. Тэгэхээр Монгол Улсын нийт хүн амын халамж хүртэгчдийн тоо маш өндөр байдаг. Тэгэхээр 1

нийгмийн ажилтанд ноогдож байгаа халамж авагчдын тоо бол өндөр. Тэгэхдээ цахимд шилжсэн учраас нийгмийн ажилтны ачаалал харьцангуйгаар буурсан.

Б.Мөнхсоёл: Соронзонболд гишүүний микрофон.

Л.Соронзонболд: Нийгмийн ажилтан олон хүнтэй ажиллаж байгаа. Тэгэхдээ яг гол нөгөө зорилтот бага орлоготой өрх нь хэд ноогдож байгаа юм бэ л гэж асуугаад байгаа байхгүй юу. Тэгээд тухайн хүний ажлын гүйцэтгэл нь тухайн хариуцаж байгаа бага орлоготой өрхөөс нь ахиц дэвшил нь гардагтай нь уялдаж байгаа юм уу. Цалин хөлс, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ нь гэж асуугаад байгаа. Тэгээд дээрээс нь тэр ахицын үнэлгээнд болохоор бол ерөнхийдөө хүнсний талон авахгүй байгаа нь л тэр тухайн айлын амьжиргаа дээшилж байгаа гэдэгт л ордог юм байна. Тэгэхээр тэр нөгөө төгсөлтийн аргачлал гэдэг төсөл чинь хамрагдсан айл өрхөөс тэр сургалтад хамрагдаад ажилд орсон нь хэд вэ гээд тиймэрхүү хэмжилттэй хэмжээс байдаггүй юм уу л гээд байхгүй юу.

Б.Мөнхсоёл: Энх-Амгалан сайдын микрофоныг нээе.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр Соронзонболд гишүүн ээ, ийм л юм байна лээ дээ. Одоо бид нар энэ халамжийн тогтолцоо, нийгмийн даатгал гээд бүх тогтолцоонуудаа бид нар босоо болгочихсон. Энэ Бадамсүрэн гишүүн ороод ирчихсэн байна. Засаг даргаар ажиллаж байсан хүн. Тэгэхээр бид нар энэ халамжийнхаа тогтолцоог, халамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлж байгаа энэ тогтолцоог бид нар хэвтээ болгох нь зүйтэй юм байна гэж ойлгож байгаа. Ер нь бол ядуурал, ажилгүйдэл гэдэг бол өнөөдөр Улаанбаатар хотоос Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны асуудал бас дангаараа биш шүү дээ. Энэ чинь салбар дундын зохицуулалтын асуудал. Тэр тусмаа тухайн сум, баг, хороодын удирдлагуудын асуудал. Тухайн баг сум, хороо дээр үнэхээр ядуу иргэн байвал тэр тухайн сумыг удирдаж байгаа, тэр багийг удирдаж байгаа энэ удирдлагуудын асуудал. Тэгэхээр одоо Улсын Их Хурал дээр өргөн барихаар бэлдэж байгаа Халамжийн тухай хуулиа өргөн барихад бид нар энэ тогтолцоог хэвтээ болгох буюу сум дээр ажиллаж байгаа, хороо дээр ажиллаж байгаа манай хөдөлмөр халамж хариуцсан нийгмийн ажилтнууд тухайн сумынхаа Засаг дарга нь тэр .../минут дуусав/

Б.Мөнхсоёл: Сайдын микрофон.

Л.Энх-Амгалан: 2-т нь түрүүн тэр төгсөлтийн аргачлалд хамрагдсан 1200 иргэдийн бараг 80 орчим хувь нь бол өөрийнхөө амьжиргааг аваад явчих, хувиараа хөдөлмөр эрхэлдэг энэ түвшинд ороод ирж байна гэсэн үг байхгүй юу. Тэгээд ганцхан хүнсний талноосоо халагдсан, авахаа больчихсон гэсэн энэ үзүүлэлт бас биш. Мэдээж хүнсний талон авахаа больсон. 2 дугаарт өөрийнхөө өрхийн орлогыг хувиараа бүрдүүлдэг, жижиг бичил бизнес эрхлэгчдийн түвшинд орж ирж байна гэдэг бол нэлээн том боломж юм байна лээ. Бараг үндсэндээ 800 гаруй хүмүүсээс өөрсдийн үндэсний брэнд яг энэ оёмол, сүлжмэл чиглэлээр үндэсний брэнд гаргаж байгаа. Бараг 50, 60 хүн нь Үндэсний брэндүүдийн патент эзэмшигч болчихсон ийм сайн жишгүүд зөндөө байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь цаашдаа энэ хөдөлмөр эрхлэлтэд халамжийн энэ тогтолцоо бол яг анхан шат дээрээ сум орон нутгийнхаа түвшин нэгжид л ажилладаг л байх ёстой. Энэ их үр дүнтэй юм байна ингэж харж байгаа.

Б.Мөнхсоёл: Ажлын хэсгээс нэмж хариулах уу. Соронзонболд гишүүн болсон уу. Батнайрамдал гишүүний микрофоныг нээе.

О.Батнайрамдал: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Сайдаас 1 асуулт байна. Бид нар илүү баялгийн шударга хуваарилалт хийх хүрээнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулиа баталсан. Тэр дундаас бас олон нийтийн хамгийн хүлээлттэй сан бол хуримтлалын нэгдсэн сан байгаа юм. Хуримтлалын нэгдсэн сан хуулийнхаа хүрээнд бол боловсрол, эрүүл мэнд, орон сууц гэсэн 3 үндсэн чиглэлээр 1 ёсондоо амьдралын чанар луу ордог яг 3 салбар луу хөрөнгө оруулалт хийнэ гэж туссан байгаа юм. 2024 онд бид нар аваад үзэх юм бол Хуримтлалын нэгдсэн санд 495 тэрбум орчим төгрөг төсөвлөгдөөд, энэ маань ипотека рүү орсон гэж ойлгож байгаа. Ингэснээрээ ипотекийн өөрийн санхүүжилтийн дүнтэй нийлүүлээд ойролцоогоор 2024 онд 1,2 их наяд төгрөгийн ипотека бол гарсан. Энэ жилийн дүнг аваад үзэх юм бол Монголбанкны хамгийн сүүлд Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн мэдээлснээр бол Хуримтлалын нэгдсэн сангаас одоогоор ямар ч нэмэлт эх үүсвэр орж ирээгүй байгаа. Тэгэхээр одоо явж байгаа ипотекийн дахин санхүүжилтээрээ бол ойролцоогоор 500 тэрбум төгрөгийн ипотека гарчихсан байгаа юм. Энэ нь бол цаашдаа 2025 оныг дуусахад бол нэмэлт эх үүсвэр 200 орчим гараад оны төгсгөлөөр 700-800 тэрбум төгрөгийн л ипотека гарах боломж байгаа юм байна.

Тэгэхээр энэ жилийн 2025 оны төсөв дээр бол бид нар 500 орчим тэрбум төгрөгийг Хуримтлалын нэгдсэн сан дээр төсөвлөсөн. Энэ мөнгө яг хэд болж төсөв дээр байгаа вэ. Төрийн сан дээр байгаа вэ. 1 дүгээрт.

2 дугаарт бас Хуримтлалын нэгдсэн сангаас энэ жилийн ипотека руу нэмэлт санхүүжилт хийх шийдвэр гарсан уу. Та энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ.

3 дугаарт ер нь ипотекийн зээл олголтыг бүтцээр нь аваад үзэх юм бол өнгөрөгч оны ипотекийн нийт зээлийн бараг 70 орчим хувь нь, ялангуяа Улаанбаатарт гарсан ипотекийн зээлийг аваад үзэх юм бол 70 орчим хувь нь зөвхөн Хан-Уул дүүрэг дээр оногдож байгаа юм л даа. Хан-Уул дүүргийн Яармаг руу. Тэр нэг ёсондоо илүү амьжиргаа сайтай, илүү өндөр өртөгтэй барилга руу илүү олгогдож байна гэсэн үг л дээ. Тэгэхээр энэ дотор зарим жишээнүүд нь бол 5, 6 дахь байрандаа ипотека авч байгаа жишээнүүд явж байгаа юм. Тэгэхээр 1 ёсондоо бид нар ипотекаар Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, мөнгө гаргаж байгаа. Монголбанкаар дамжуулж бид нар чинь илүү хүртээмжтэй байх талаасаа гаргаж байгаа шүү дээ. Амьдралын чанарт илүү хөрөнгө оруулах талаар. Гэтэл энэ нь ингээд илүү чадвартай хүмүүсийн 5, 6 дахь байр болоод байх юм бол ипотекийн бодлого чинь өөрөө буруу яваад байна л даа. Тэгэхээр энэ дээр та бас байр сууриа илэрхийлээч. Ер нь энэ бодлого өөрөө зөв явахгүй бол буцаад яг тэр Баялгийн сангийн гол зарчим илүү баялгийн тэгш хуваарилалтыг илүү шударга хуваарилалтыг гэж хэлмээр байна. Шударга хуваарилалтыг хийх механизм маань өөрөө бодит амьдрал дээрээ буруу яваад байна л гээд байгаа юм л даа. Тэгэхээр энэ дээр таны байр суурийг сонсьё.

Б.Мөнхсоёл: Сайдын микрофоныг нээе.

Л.Энх-Амгалан: Батнайрамдал гишүүн ээ, ийм байгаа. Хуримтлалын сангийн эх үүсвэр чинь нөгөө уул уурхайн компаниудын 34 хувьд ноогдох ноогдол ашгаас орж ирж байгаа шүү дээ. Тэгэхээр өнгөрсөн жил бол 496 тэрбум төгрөг бол энэ

санд төвлөрсөн. Энэ сангийн төвлөрсөн хөрөнгөөр бол бид нар ипотекийн зээлийн эх үүсвэрийг нэмсэн. Хуучин ипотекийн зээлийн эх үүсвэр бол Монголбанкнаас жил бүхэн 500 орчим тэрбум төгрөг гаргадаг байсан бол энэ 1-1,2 их наяд болж нэмэгдсэн. Жил бүхэн 5-6 мянган өрх маань энэ 6 хувийн зээлд хамрагдаж, орон сууцтай байдаг болсон бол энэ тоо нэмэгдэж, 11-12 мянган өрх хамрагддаг болсон. Гэхдээ энэ жилээс бид нар ерөнхийдөө энэ ипотекийн зээлийнхээ бодлогод бид нар өөрчлөлт хийхгүй бол хүн бүхэн 6 хувийн ипотекийн зээл авах юм шиг 1 ийм буруу ойлголт нийгэмд маш их төрсөн байна. Тэр тусмаа яг таны хэлж байгаатай холбоотой 2 дахь, 3 дахь орон сууц авчихсан. Ипотекийн зээлээр 6 дахь орон сууцаа хүртэл авчихсан хүн байгаа шүү дээ. Тэгээд түрээслээд амьдарч байдаг.

Гэтэл яг нөгөө 6 хувийн зээл авах шаардлагатай байгаа хөдөө, орон нутагт амьдарч байгаа, эсвэл гэр хорооллоос орон сууц руу шилжих гэж байгаа энэ утааны асуудлууд, түгжрэлийн асуудлуудыг шийдэж байгаа яг энэ бодлоготойгоо уялдсан ийм тогтолцоонууд бас хийж чадаагүй юм байна.

Тийм учраас Ерөнхий сайдаар ахлуулсан Үндэсний орон сууцын хороо байгуулагдаж ажиллаж байгаа. Энэ орон сууцын хүрээнд бид нар ер нь дунд, урт хугацаанд Монгол Улсад ипотекийн зээлийн тогтолцоо ер нь яг ямархуу тогтолцоо байх вэ гэдэг дээр 3, 4 шийдлүүдийг гаргасан. Ингээд удахгүй Улсын Их Хурал дээр Ипотекийн зээлийн санхүүжилтийн тухай хуулийг өргөн барих гэж байна. Ипотекийн зээлийн санхүүжилтийн тухай хууль. Энэ хууль батлагдаж гарснаар ер нь иргэн хүн зорилтот иргэдэд яг ямархуу хэмжээний ипотекийн зээл гэдэг чинь өөрөө хөнгөлөлттэй зээл шүү дээ. Төрийн хөнгөлөлттэй зээл. Тийм учраас энэ зээлд хэн хамрагдах вэ, яаж хамрагдах вэ, ямар нөхцөлтэй байх вэ, эх үүсвэрүүд нь яг ямар байх вэ гэдэг бол ойрын хугацаанд энэ хуулиар эрх зүйн зохицуулалтаар их ойлгомжтой болно гэж харж байгаа. Энэ жилийн хувьд харамсалтай нь яг одоогийн байдлаар бол хуримтлалын сан дээр 1 ч ноогдол ашиг орж ирээгүй байна.

Гэхдээ ерөнхийдөө ноогдол ашгууд жилийн эцсээр компаниуд ноогдол ашгаа зарладаг. Тийм учраас Эрдэнэс Монгол компани, Эрдэнэттэй ярихад бол 10-12 сар луу энэ жилийн хуримтлалын санд хуримтлуулах ноогдол ашгийг хуваарилуулна гэсэн ийм төлөвтэй байгаа. Тэгээд харамсалтай нь нүүрсний борлуулалт маш муу байна. Урьдчилсан байдлаар чинь манай төсөв дээр ирж байгаа орлогын алдагдал, бууралт бол бараг 2,4 их наяд хүрч байгаа юм байна лээ шүү дээ. Төсвийн орлого нь бууралт 2,4 их наяд. Үүнтэй уялдуулж Эрдэнэс Монголын компаниудын Хуримтлалын санд төвлөрүүлэх ёстой мөнгөн дээр бол бид нарын төлөвлөсөн 500 тэрбумдаа хүрэхгүй байх ийм эрсдэлүүд бас үүсэж байна.

Тэгээд дан ганц хуримтлалын сангийн эх үүсвэрээр бид нар бас ипотекийнхээ зээлийн эх үүсвэрийг шийдээд явж болохгүй. Дунд, урт хугацаанд бид нар ипотекийн банк, төрөлжсөн банкнуудыг гаргаж ирэх энэ хувилбаруудаар бид нар ажиллаж байна. Яг таны хэлж байгаа Сингапурын загвар луу иргэн хүн өөрөө хуримтлалаа хийсэн тохиолдолд тэр хуримтлалыг дэмждэг Matching fund схем маягаар Казахстан гэх зэрэг улсууд бол ингэж хийсэн юм байна лээ. Тэгээд цаашдаа бид нар иргэдийн хуримтлал дээр дэмжсэн хуримтлалуудаа дэмжиж явуулахдаа их сайн жишээнүүд гарч байгаа. Хуримтлалын сандаа 1072 ширхэг

хувьцааныхаа ноогдол ашгийг хүүхдийнхээ мөнгийг хуримтлуулсан иргэдийн тоо нэмэгдэж байна.

Тэгэхээр энэ хуримтлалуудыг бид нар дэмжиж байж хуримтлал хийсэн иргэдэд нь эргэж хамгийн тэргүүн ээлжид ипотекийн зээлд хамрагдах боломжуудыг бодлогын дэмжлэгийн арга хэмжээнүүдийг хийх нь зүйтэй юм байна. Дунд, урт хугацаанд бодлого нь илүү их үр дүнтэй юм байна гэж ингэж харж байгаа.

Б.Мөнхсоёл: Батнайрамдал гишүүн тодруулж асууя. Бадамсүрэн гишүүний микрофоныг нээгээд өгөөрэй.

О.Батнайрамдал: Ипотекийн зээлийн санхүүжилтийн тухай хууль Засгийн газраас өргөн барьж байгаа гэж. Өргөн баригдчихсан уу. Одоо өргөн барих гэж байгаа юм байна. Энэ их зөв зүйл. Ер нь бид нар эрх зүйн зохицуулалт хийж байж ипотек буцаад яг зорилтот бүлэг рүүгээ очихгүй бол ер нь нийт олгогдсон ипотекийг дүгнээд үзэх юм бол зорилтот бүлэг рүүгээ үнэхээр очиж чадсан уу гэвэл дийлэнх нь бол очиж чадаагүй л байх гэсэн дүгнэлт гарах байх гэдэгт бол итгэлтэй байна.

Нөгөө банкнууд ипотек олгохдоо мэдээж эрсдэлээ хараад, хамгийн чадвартай, хамгийн эрсдэл багатай зээлдэгч рүүгээ олгохоор бидний нөгөө яг зориод байсан гэр хорооллоос орон сууц руу орох гэж байгаа хүмүүс дандаа орхигдож, эсвэл жагсаалтад орчихоод хэзээ ч биелдэггүй олон жилийн жагсаалтад маш олон иргэд явж ирсэн. Эндээс бол миний сонгогдсон Сүхбаатар, Чингэлтэй дүүргээс маш олон иргэд энэ талаар бол гомдол гаргаж, хүсэлт гаргаж байгаа юм. Зарим иргэд маань хүртэл бараг намайг ипотект оруулаад өгөх юм. .../минут дуусав/

Б.Мөнхсоёл: Нэмэлт 1 минут.

О.Батнайрамдал: Тэгэхээр зарим иргэд маань намайг бараг ипотект оруулаад өгөх юм шиг над руу хүсэлтээ явуулаад, тэр дотроо өөрсдийнхөө мэдээллийг оруулаад ингээд явж байгаа. Тэгэхээр энэ дээр бол маш их эрэлт байгаа юм. Тэгээд бас 1 зүйлийг бодож үзээсэй гэж бодож байна Засгийн газрыг. Ковидын үед бол бид нар түрээслэн өмчлөх хэлбэрээр 150 тэрбум төгрөгийг бол ковидын үед онцгой нөхцөлөөр ингээд гаргасан. Монголбанкны хийж байгаа мэдээллээр бол энэ түрээслэн өмчлөх тэр хэлбэрээр гаргасан 150 тэрбумын эргэн төлөлт бол маш сайн явж байгаа юм байна лээ. Тэгэхээр өнөөдөр яг нийт иргэдийн ипотекийн авах гэж байгаа зорилтот иргэдийн хэдэн хувь нь тэр 30 хувиа төлөөд авч чадна гэх юм бол энэ чинь бас шал ондоо дүн харагдаад байгаа юм л даа.

Тэгэхээр харин түрээсэлж аваад, чадвартай болохоороо эсвэл тэр цаашдаа хэдэн жилийн дараа өмчлөөд явах хэлбэрийг маш олон иргэд хүсээд байна. Тэгэхээр энийг бас Засгийн газар ер нь бодлогын зүгээсээ ч гэсэн зайлшгүй тэр ипотекийн бодлого дээрээ бол авч үзэх ёстой юм байна лээ гэж бодож байна.

Б.Мөнхсоёл: Сайдын микрофон.

Л.Энх-Амгалан: Тантай санал 1 байна Батнайрамдал гишүүн ээ. Ер нь бол бид нар ипотекийнхээ тогтолцоог эхлээд зөв хийж авах ёстой. Мэдээж түрээслээд өмчлөх гэдэг энэ хувилбарууд бас Барилга, хот байгуулалтын яам дээр хийгдэж байгаа. Хот дээр хийгдэж байгаа ийм хувилбарууд. Цаашдаа амины орон сууцуудыг ч гэсэн дэмжих ийм бодлогууд бас явна гэж бодож байгаа.

Гэхдээ бид нар нэг зүйл дээр их сайн анхаармаар юм байна. Юу гэхээр бид нар ипотекийн зээлийн хүүг бууруулаад байдаг. 8-ыг 6 болгочихсон. Очер нь ихсээд байдаг. Гэтэл нөгөө талдаа барилгын үнэ нэмэгдээд байгаа байхгүй юу. 1м2 нь 3 сая төгрөг байсан орон сууц ипотекийн зээлийг 8 хувиар олгож байхад 3 сая байсан метр квадрат өнөөдөр 5, 6 сая дол төгрөг болчихоор эргээд хэчнээн ч бид нар ипотекийн зээлийн хүүг бууруулаад байхад эргээд нөгөө иргэндээ очихгүй барилгын компаниудаа санхүүжүүлээд байдаг нэг ийм л тогтолцоо болчихсон юм байна лээ шүү дээ. Тийм учраас бид нар энийг тогтолцоогоор нь яг энэ барилгынх нь эрэлт нийлүүлэлттэй уялдуулсан тэр метр квадрат нь орлогод нийцсэн орон сууцуудынх нь тэр хувилбартаа л их сайн зохицуулж хийх ёстой юм байна л гэж ингэж харж байгаа.

Б.Мөнхсоёл: Мандхай гишүүний микрофоныг нээе.

М.Мандхай: Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хэдэн асуулт байгаа юм. Ер нь энэ яг үнэнийг хэлэхэд Статистикийн үндэсний хорооноос гаргаж байгаа ядуурлын түвшнийг би ер нь бас яг үнэн, зөв мэдээлэл гаргаж байгаа дээр эргэлзээд байгаа юм. Яагаад гэхлээр бид нар нөгөө л ярьдаг ядуурлын түвшин 27,1 хув гэдэг тоог ер нь ярьсаар ирсэн боловч яг бодит амьдрал дээр бол ядуурлын түвшин өшөө буурч байгааг ер нь бол захын иргэдтэй уулзахад бол хэлээд байгаа юм.

Тэгээд бид нар зүгээр цагаан дээр хараар биччихсэн тоо л яригдаад байгаа боловч яг бодит амьдрал яг ямар хүнд нөхцөлтэй байгаа вэ гэдгийг ерөөсөө анзаарахгүй ч юм уу эсвэл яадаг юм. Надад энэ тоонууд алдаатай юм шиг санагдаад байгаа. Жишээлбэл, ялангуяа нөгөө бичил, жижиг дунд бизнес эрхэлж байгаа эрхлэгчдийг би сая 100 айлаар яваад бизнес эрхлэгчтэй уулзсан. Ерөнхийдөө бол манай нийт иргэдийн тансаг хэрэглээ буюу цагаан сараар хөшгөө сольдог, хөөрхөн жижигхэн засвар энэ тэр хийчихдэг байсан овоо 100 айл дээр борлуулалт нэмэгддэг байсан бол одоо больсон. Иргэд үндсэндээ ганц ажилтай байгаад хүнсээ авч чадахгүй нөхцөл байна. Бид нар тансаг зэрэглэлээ бүгдийг нь танасан. Өнөөдөр бараг 1 метр нь 60 мянгаар авдаг байсан тансаг зэрэглэлийн хөшгийг 30 мянгаар хүртэл авч чадахгүй болох түвшинд иргэдийн амьдрал, худалдан авах чадвар эрс буурч байна гэдгийг захын худалдаачид хэлж байгаа юм.

Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр ер нь энэ хөдөлмөр эрхлэлт яг бодитой ер нь сүүлийн 3 жилийн хугацаа, ковидоос хойш ер нь яг ямар байгаа вэ. Би статистикийг харахад сүүлийн 5 жилийн статистик харахад эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт жил ирэх тусам буурч байсан. Маш олон шалтгаанаар, цалин хөлс, тэр цагийн уян хатан байдлаас гээд шалтгаанаар хөдөлмөр эрхлэлт буураад байгаа байхгүй юу. Тэгээд энэ статистикийг харахаар хөдөлмөр эрхлэлт буураагүй, бараг өссөн гэсэн үзүүлэлттэй харагдаад байна л даа. Тэгэхээр надад яг энэ бодитой тооцооллоо дахиад 1 танилцуулж өгөөч. 1 дүгээрт.

2 дугаарт гадаадад ажиллах хүчний тоо эргээд бас өсөөд байгаа. Одоо ингээд захын яг ажиллах хүчний насны 25-аас ялангуяа 45 насны энэ бүлэг бол болж өгвөл гадагшаа гаръя гэдэг саналыг ярьдаг болчихсон. Тэгэхээр энэ гадагшаа гарч байгаа урсгал нэмэгдээд байдаг, хөдөлмөр эрхлэлт чинь өөрөө ингээд худалдан авах чадвартай буураад, бизнес эрхлэх боломжгүй ийм түвшинд очоод байгаа юм биш үү. Тэгэхээр энэ бодит амьдрал болон энэ статистик тоо ер нь яг ямар байгаа юм бэ гэдгийг би дахиад тулгаад асуумаар байгаад байгаа юм.

Иргэдийн орлого угаасаа буурч байгаа. Тэгэхээр яамны зүгээс бодлогоор яг яаж энийг нэмэгдүүлэх дээр яг ямар ажлыг хийхээр төлөвлөж байгаа юм бэ. Ер нь ямар үр дүнтэй хөтөлбөр хэрэгжүүлэе гэж бодож байгаа вэ гэдгийг асуумаар байна

2 дугаарт энэ хуулийн хэрэгжилт.../минут дуусав/

Б.Мөнхсоёл: Нэмэлт 1 минутыг нь өгчихье Мандхай гишүүнд.

М.Мандхай: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2011 онд шинэчлэгдэн найруулснаас хойш дахиад яам дээр бол явж байсан. Энэ хуулийн ер нь хэрэгжилт яг ямар хувьтай байгаа юм. Энэ явц нь ер нь ямар байгаа вэ. Энэ хууль дээр одоо яг гадаад ажиллах хүчийг бууруулж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ЖДҮ-лэгчдийг нэмэгдүүлэхтэй холбоотой ер нь ямар ямар эрх зүйн орчнууд сайжирч байгаа юм бэ гэдэг дээр хариулт өгөөч.

Б.Мөнхсоёл: Энх-Амгалан сайдын микрофоныг өгье. Нэгмөсөн 3 минутаар өгчихье. Тэгэхгүй бол хугацаа хангалтгүй байна.

Л.Энх-Амгалан: Мандхай гишүүний асуултад хариулъя. Мандхай гишүүн ээ, одоо бид нар Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал гээд улирал тутам гаргаж байгаа ийм статистик зарладаг. Энэ дээр бол хөдөлмөр эрхлэлттэй холбоотой ажиллах хүч, ажиллагсад, ажилгүй хүн, ажлаас гадуурх хүн ам, ажиллах хүчний оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшин гээ үүгээр л бид нар барометр болж харж байгаа. Энэ тоо бол сүүлийн жилүүдэд харьцангуй бодитой тоо болж байгаа юм байна гэж харж байгаа. Энэ тоог илүү боловсронгуй болгох чиглэл рүү бид нар бас хөдөлмөрийн зах зээлийнхээ гол гол үзүүлэлтүүдийг хэмждэг ийм их өгөгдлүүдийн платформуудыг боловсруулж байна. Ер нь бол энэ хөдөлмөрийн зах зээл, өнөөдөр Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл гэж яг өөрөө юу вэ. Яг ямар нөхцөл үүсчээд байгаа юм бэ. Энэ ажилгүй гээд 70-80 мянган хүн л зарлагдаад л байдаг. Сүүлийн 20, 30 жил зарлагдаад байдаг энэ яг үнэхээр ажилгүй иргэд мөн юм уу. Хэд нь өнөөдөр ажилд зуучлагдаад байгаа юм гэдэг энэ бүх асуудлуудыг бас хэмжих хэмжүүр нь тодорхой болгох ийм их өгөгдлийн платформуудыг бид нар боловсруулж байгаа юм.

Тэгэхээр өнөөдөр хөдөлмөрийн зах зээл дээр үүсчээд байгаа гол асуудал, гажуудлууд бол 1 дүгээрт ур чадварын гажуудлууд байна. Ажил олгогч нарын хүсэж байгаа ур чадваруудыг манай дээд боловсрол, мэргэжлийн боловсролын тогтолцоо олгож чадахгүй байна. Энэнээс болсон гажуудал.

2 дугаар асуудал бол ерөөсөө манай хөдөлмөрийн зах зээл дээр байгаа ажиллах хүчний хомсдол бодитой маш том асуудал болсон. Энэ бол хүмүүс бүгдээрээ халамж авчхаад, бүгдээрээ ажил хөдөлмөр эрхлэх сонирхолгүй болчихсон юм биш. Энэ яг юунаас болсон өнөөдөр энэ хомсдол бий болчихоод

хэдэн оноос яг ямар ямар нөхцөл байдлууд үүсээд ийм хомсдол бий болчихсон юм бэ гэхээр ерөөсөө нөгөө бага төрөлтийн үед 1990-2005 оны хоорондын бага төрөлтийн үед л бид нар маш их том боломжуудаа алдчихсан. Жилд төрүүлэх ёстой хүүхдийнхээ бараг үндсэндээ 20-30 мянган хүүхдүүдийг тэр үед төрүүлж чадаагүй. Үүнээс үүсээд нэгдсэн дүнгээрээ бол тэр үед төрсөн хүүхдүүд өнөөдөр хөдөлмөрийн зах зээл дээр 25-35 насны залуучууд зонхилох залуучууд байх ёстой. Ер нь бол 240-280 мянган боломжуудыг л Монголчууд алдчихсан юм байна лээ. Энэ бол маш том тоо байхгүй юу.

Манайх чинь хөдөлмөрийн зах зээл багатай. 1,2 саяын хөдөлмөрийн зах зээлтэй улс орон. Дахиад дээрээс нь гадаад руу бид нар 210 мянган залуучууд алдчихсан. Ингээд үндсэндээ бол 480 мянгаас 510 мянган ажиллах хүчин өнөөдөр Монголын хөдөлмөрийн зах зээл дээр сох дутчихсан байхгүй юу. Үүнээс болоод өнөөдрийн ажиллах хүчний асуудлууд, ажиллах хүчний хомсдолын асуудлууд үүсчихсэн байна. 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал бол ерөөсөө цалин хөлс, бүтээмжийн асуудал байхгүй юу. Монгол хүний нэг.../минут дуусав/

Б.Мөнхсоёл: Нэмээд 1 минут.

Л.Энх-Амгалан: Монгол хүний 1 цагт авч байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ чинь бараг үндсэндээ 1 доллар 10 цент л байна шүү дээ. 1 доллар 20 цент л байна шүү дээ. Тэгээд бид нар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэх гээд байдаг гол зүйл чинь ерөөсөө энэ дээр л байгаа байхгүй юу. Өнөөдөр Монгол хүн 1 цагт 1 доллар 10 центийн үнэлгээтэй байхад дундаж улсуудынх бол 5-7 доллар болчихсон байна шүү дээ. Тэгэхээр энэ залуучууд Солонгос руу явах нь аргагүй шүү дээ. Австрали руу явах нь аргагүй шүү дээ. Тийм учраас Монгол хүний бүтээмж, Монголын эдийн засгийн бүтээмжүүдийн өсөлтүүдийг сайжруулж байж цалин хөлс өндөртэй байх энэ ажлын байруудыг их олон мянгаар бий болгох ёстой юм байна гэж ойлгож байгаа. Энэ дээр маш сайн жишээнүүд бий. Уул уурхай тодорхой дэлхийн дундаж түвшинд хүрсэн. Цалин хөлс, бүтээмжийн түвшин хүрсэн. Мэдээлэл технологийн салбар энэ түвшинд хүрсэн. Банк, санхүүгийн салбарын түвшинд хүрсэн. Одоо хамгийн их ажлын байр бий болгож байгаа хөдөө аж ахуйн салбарууд дээр өнөөдөр цалин хөлс бага, бүтээмж бага байгаа учраас л манай Монгол залуучууд ажиллах сонирхол их багатай байдаг юм байна гэж харж байгаа юм. Тэр хүрээндээ Засгийн газраас хэрэгжүүлж байгаа 14 мега төсөл хэрэгжээд, ДНБ-ий 10 мянган доллар хүргэж чадах юм бол гадагшаа гарч байгаа гадагшаа урсгал .../минут дуусав/

Б.Мөнхсоёл: Мандхай гишүүн тодруулга 1 минут.

М.Мандхай: Тэгэхээр одоо хэдүүлээ чөтгөрийн тойрогт орчхоод байгаа байхгүй юу. Нөгөө аль нь хаанаас эхлэх вэ гэдэг нь тодорхой бус. Тэгэхээр ингээд байгаа байхгүй юу. Та бол өөрөө бизнес эрхэлдэг хүн сайн мэдэж байгаа. Бид нар яг хаанаас эхлэх ёстой вэ. Тэгвэл та бизнесийн салбарыг мэддэг хүний хувьд би асуучихъя. 14 мега төсөл гэж яриад байдаг. Яг үндсэндээ 14 мега төслөөс орж ирэх өгөөж чинь өөрөө урт хугацаа байхгүй юу. Бид нар өнөөдөр яг богино хугацаанд тухайн 14 мега төслийг хөгжүүлэхэд ажиллах хүч тийшийгээ зарцуулж байгаа боловч өөрөө энэ чинь тогтвортой ажлын байр биш. Энэ ингээд төсөл хэрэгжээд дуусна. Тэгвэл энд ядуурал буураад, гадагшийгаа хүмүүс нэмэгдээд

ажиллах хүч хомсдоод байна. Цалин хөлс нэмэгдэхгүй байна гээд. Ер нь бол сууриас нь эхлэх юм бол залуучуудад бол үндсэндээ цалин хөлс нь амьдралд нь хүрэлцээтэй, ядаж 1 байр авах боломжтой, машин авах боломжтой ийм .../минут дуусав/

Б.Мөнхсоёл: Цөөн гишүүнтэй юм чинь гээд дэггүй, боломж олгоод байгаа шүү дээ. 1 минут.

М.Мандхай: Тэгэхээр цалин хөлсийг нэмэгдүүлээд, тогтвортой ажлын байрыг хангана гэдэг чинь өөрөө 14 мега төсөл гэж би бол харахгүй байгаад байгаа юм. Тэгэхээр та яг энэ дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны гол бодлогыг хариуцаж байгаа хүний хувьд хаанаас бид эхлэх ёстой юм бэ. Яагаад гэхлээр бид нар 2026 оны төлөвлөгөө батлах гээд сууж байгаа. 14 мега төслийг явуулаад явахаар энэ асуудлууд чинь буурах юм уу, буурахгүй юм уу. Яг ийм нөгөө жижүүрийн маягийн биш, одоо яг бодлогын шийдэл дээрээ хэд хэдүүлээ ярилцаад, энэ 2026 оны төлөвлөгөө, 2027-2028 оны төсвийн хүрээний мэдэгдэл гээд олон асуудлууд яригдаж байгаа үед бид нар яг энийгээ тогтож авахгүй бол үндсэндээ сүүлдээ манайд 27,1 хувийн ядуурлын түвшин чинь 30 гараад явчихсан байгаа шүү гэдгийг би бол энэ статистик тоонд итгэхгүй байгаад байгаа. Тийм учраас бид нар яг хаанаас эрэмбэ дараагаараа зөв эхлэх вэ. Ядаж энэ байгаа ажиллах хүчээ ажлын байртай нь залгуулаад, тогтвортой орлоготой байлгахад бид юунаас эхлэх вэ гэдгийгээ л анхаармаар байна. Тэгэхээр энэ нь өөрөө энэ..../минут дуусав/

Б.Мөнхсоёл: Мандхай гишүүн үг дээр бас хэлж болно шүү дээ. Дараа нь үг байгаа. Дахиад Энх-Амгалан сайдын микрофоныг нээе.

Л.Энх-Амгалан: Үгүй ээ, хаанаас эхлэх гээд байгаа юм бэ гэж. Тогтолцооноосоо л эхэлдэг байх даа. Бид нар тогтолцоогоо зөв болгож байж, оношоо 1 дүгээрт зөв тавьж байж зөв эмчилгээ явах ёстой. Тийм учраас өнөөдөр Монголын хөдөлмөрийн зах зээл гэдэг өөрөө яг юу юм бэ гэдгийг бид нар их сайн ойлгомоор юм байна лээ Мандхай гишүүнээ. Яг хөдөлмөрийн зах зээл. Хөдөлмөрийн зах зээл дээр оролцож байгаа хүмүүсийн тоо, албан бус сектор дээр ажиллаж байгаа хүмүүсийн тоо, тэгээд энэ албан бусаас албан сектор луу хэд шилжиж байна. Тодорхой аль аль сектор дээр ажлын байрууд нь тодорхойгоор бодитойгоор бий болж байна. Аль аль сектор дээр ажлын байрууд нь алга болж байна гэдэг энэ бүх зүйл тогтолцоо дээрээ л бид нар зөв оношилгоонууд хийж байж энэ ажлууд 1 дүгээрт хийгдэх ёстой гэж ойлгох хэрэгтэй.

Тэрнээс 14 мега төсөл хэрэгжингүүт Монгол Улсын ажилгүйдэл 0 болоод, бүх хүмүүс ажилтай, орлоготой болчихно гэж би бодохгүй байна л даа. Тантай адилхан бодолтой байна. Тэгээд 14 мега төсөл гэдэг бол ерөөсөө макро түвшиндээ бид нар эдийн засгийн үзүүлэлтээ 6-7 хувьтай бариад, ДНБ 10 мянган доллар хүрэхэд бол .../минут дуусав/

Б.Мөнхсоёл: Сайдыг микрофон 1 минут.

Л.Энх-Амгалан: Бид нар энэ тооцоо судалгаанууд бас энэ бодлогын зөвлөмжүүдийг олон улсын байгууллагууд бид нарт их бичиж өгсөн л дөө. Тэгээд бичиж өгсөн байдаг юм байна лээ. Ер нь бол ингээд гадагшаа ажиллах хүчнээ алдаж байсан энэ улс орнууд Солонгос байна, Турк байна, Польш байна. Эд нар

яг хэзээ хүмүүс нь гадагшаа явахгаа зогссон юм бэ гэхээр 1 хүнд ноогдож байгаа ДНБ 10 мянган долларт хүрэхээр л зогсдог юм байна лээ шүү дээ. Тийм учраас бид нарын зориод байгаа энэ зорилт бол яаж ийж байгаад 1 хүнд ноогдох ДНБ-ээ 1 10 мянган долларт хүргэж чадах юм бол Монгол хүний авах цалин хөлс 1 мянган долларт хүрэх, 1 цагийн бүтээмж 5-8 долларт хүрч байж л энэ асуудлууд шийдэгдэх юм байна гэж бодож байгаа юм. Гал унтраасан арга хэмжээ аваад яваад байж болохгүй гэж би тантай санал нэг байна. Тийм учраас бол тогтолцооны шинэчлэлийн асуудлуудыг бид нар ярьж байгаа. Энэ хүрээндээ бид нар Халамжийн хууль, Нийгмийн даатгалын даатгалын хууль, тэгээд мөн Хөдөлмөр эрхлэлтийн хуулиа өргөн барьж байна. Тэгээд нөгөөдөр бас таныг урьж байна. Энэ ордон дээр Монгол Улсын Нийгмийн хамгааллын тогтолцооны системийн шинжилгээг бид нар хийлгэсэн. Энэ системийн шинжилгээг бид нар танилцуулах .../минут дуусав/

Б.Мөнхсоёл: Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: Манай Дэд хороо хүний хөгжлийн асуудлаар мэдээлэл сонсож байгаад би бол их баяртай байгаа. Ер нь ингээд цементэд хөрөнгө оруулдаг. Тэгээд ер нь энэ бодлогоо яаж өөрчлөх вэ. Хүний хөгжил бол 1 дүгээрт шүү дээ. Байгалийг хүний баялаг болгох энэ бодлого бол өөрөө их том бодлого. Тэгэхдээ хугацаа шаарддаг. Тийм учраас энийг бол их тийм зоригтой улс төрчид л хийх байх. Энэ бол 10, 20 жил хамгийн наад талын хугацаанд зарцуулагддаг. Тэгэхээр энд 1 ийм судалгаа байна л даа. Хөрөнгө оруулалтын үр өгөөж дотор 5 үзүүлэлтүүд авсан. Эндээс би ядуурлын бууруулахад үзүүлэх нөлөөнийх нь талаар харлаа.

Тэгээд хүүхэд, боловсролд оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнд бол ядуурал бол илүү тогтвортой буурч, алсдаа ажил эрхлэлт нэмэгдэнэ. Дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт нь бол хязгаарлагдмал. Сая Мандхай гишүүний хэлдгээр. Халамжид оруулсан хөрөнгө оруулалт бол түр зуурын бууралт өгнө. Үр нөлөө богино хугацаатай гээд ингээд тодорхой заачихсан байгаа юм. Тэгэхээр эндээс юу харагдаж байна гэхээр бид нар ерөөсөө дотоодын бүтээгдэхүүнд эзэлж байгаа хүүхэд боловсролдоо оруулах хөрөнгө оруулалтаа л эрс нэмэгдүүлэх, энэ төсвийн доторх бүтцэд зоримог алхам хиймээр байна. Энэ дээр нь сайд энэ санаачилгыг хэрэгжүүлж ажиллавал улс төрийн хувьд бол Их Хурлын гишүүд манай бодлогын хороо бүрэн дэмжих байх гэж би бол хувьдаа ийм бодолтой байна.

Тэгээд техникийн мэргэжлийн боловсролд ер нь анхаарах талаар ямар бодлого баримталж байгаа вэ. Одоо байгаа сургалтын тоог хамгийн багадаа 2-3 дахин нэмэгдүүлэх хэрэгтэй. Ингэхийн тулд ийм цогц бодлого хэрэгжүүлнэ, Үйлдвэр дээр ажиллана, хувийн хэвшилтэй хамтарч тэндээс тодорхой цалинг нь олгоно. Тэгээд онолын хичээлээ эндээ мэдээж суралцана. Тэгээд ингээд бэлтгэгдэж байгаад хагас онол, хагас нь практик, үйлдвэр дээр бэлдэж байгаад ажлын байранд шилжээд явахгүй бол боловсролгүйгээс шалтгаалаад олон туслах ажилтнаас өгсүүлээд олон мэргэжлийн ажилчид гадаадаас орж ирч ирээд байгаа юм. Тэгэхээр энэ техник мэргэжлийн боловсрол дээр ер нь яаж анхаарах бодлого барьж байна.

Хүүхэд, боловсролд оруулах энэ төсвийг эрс нэмэгдүүлэх талаар ер нь ямар ажил хийхээр төлөвлөж байна. Үндэсний баялгийн сангаас хүүхдийн хөгжил болон

ЖДҮ-лэлд мөнгө зарцуулах, хөрөнгө хуваарилах талаар ямар бодлого барих вэ. Орлоготой байж байж орон сууцтай болно гэж Энх-Амгалан сайд хэлж байсан. Би үүнтэй бол 100 хувь санал нэг байгаа. Тэгэхээр ЖДҮ-лэл буюу хувь хүний хүн бүрийн хийж чаддаг ажлыг нь дэмжихэд нь зориулсан хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг яаж нэмэгдүүлэх вэ. Төсвөөс хараат бусаар буюу баялгийн сангийн хуримтлагдаж байгаа Хөгжлийн сан, Хуримтлалын сан, Ирээдүйн өв сангийн хуулиудад шинэчлэл хийж, өөрөө энэ нь хүнийхээ хөгжилд хөрөнгө .../минут дуусав/

Б.Мөнхсоёл: Энх-Амгалан сайдын микрофоныг нээе.

Л.Энх-Амгалан: Бадамсүрэн гишүүнтэй бол би санал 1 байна. Ер нь хүний хөгжүүлсэн улс орон хөгждөг. Тийм учраас хүний хөгжил рүүгээ бид нар хөрөнгө оруулалтаа хийх ёстой гэж. Тэгэхдээ бид нар эхлээд мөнгөтэй болох ёстой. Тэгээд эхлээд мөнгөтэй болж байж бид нар энэ мөнгөө хүний хөгжилтэйгөө зарцуулах ёстой. Тэгэхээр ер нь хамгийн өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт бол угаасаа боловсрол. Би бол тантай санал нэг байна. Бас өнгөрсөн 3 жил Боловсролын сайдаар ажиллаж байх хугацаанд бас энэ боловсролд хийсэн хөрөнгө оруулалтыг би Боловсролын сайд дээр ажил авахад манай боловсролын салбарын санхүүжилт 1,7 их наяд байсан. Би ажил хүлээлгэж өгөхөд 4,2 их наядын 3 дахин хөрөнгө оруулалтыг нэмсэн. Ер нь судалгаагаар СӨБ-д хийсэн 1 доллар буцаад 13 доллар болдог. Хамгийн их өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт байдаг. Тэр хугацаандаа Оюун-Эрдэнийн Засгийн газар бас цэцэрлэгийн асуудлуудыг шийдсэн. Одоо ингээд энэ жил Монгол Улсын Засгийн газар энэ 2026 оныг боловсролыг дэмжих жил болгож зарлаж байна. Энэ бол маш том ийм боломж. Тэгэхээр улс орнууд бол энэ хүний капиталараа өрсөлддөг болсон. Тийм учраас хүний капиталд хийж байгаа хөрөнгө оруулалт бол хамгийн дунд болон урт хугацаанд хамгийн их өндөр өгөөж өгдөг ийм юу байгаа.

Тийм ч учраас хүний хөгжлийн индекс гэж ерөнхий ярьдаг болсноос одоо цаашаа бол их задруулж, улс орнууд энэ хэмжигдэхүүнүүдийг ярьдаг болсон юм байна. Human flourishing гэж бас тодорхой үзүүлэлтүүдийг хардаг болсон байна. Энэ хүрээндээ ч гэсэн Статистикийн ерөнхий газартай манайх хамтарч, цаашдаа ч гэсэн бид нар энэ ядуурлын үзүүлэлтийг зөвхөн ядуурлын түвшин, ядуурлын шугам гэдэг тэр ойлголтоос биш илүү өргөн хүрээнд ядуурлын олон хэмжээст хэмжүүрээр ядуурлын хэмждэг, тэр дээр нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийн асуудлууд боловсролын асуудлууд гэх мэтчилэнгээр олон талаас нь бас амьжиргааны чанарын асуудлууд, жишээ нь амьдарч байгаа орон байрууд нь тэр ариун цэврийн байгууламжтай холбогдсон байна уу. Орон сууцын нөхцөлүүд нь яг ямар байгаа юм. Хоол тэжээлийн илчлэгийн хэмжээнүүд, боловсрол дээр бол сургуулийн хамрагдалтууд, насанд хүрэгчдийн суралцсан жилүүд, ажил эрхлэлт нийгмийн хамгаалал дээр ажилгүйдэл, нийгмийн даатгалд хамрагдсан хамрагдалтууд, мэдээлэл харилцаа технологийн хүртээмж ингээд мэдээж өмч, үл хөдлөх хөрөнгө, мөнгөн хадгаламж гээд их олон хувилбараар бас улс орнууд энэ юугаа хэмждэг юм байна. Улс орныхоо амьдралын чанаруудыг хэмждэг юм байна. Тэгэхээр энэ чиглэл рүү бид нар энэ аргачлалууд, энэ хэмжээс үзүүлэлтүүдээ бас сайжруулах зайлшгүй шаардлага байна гэж бас би бодож байгаа.

Мэргэжлийн боловсрол бол хуучин энэ яаманд байсан. Би бас Боловсролын сайд болоод энэ мэргэжлийн боловсролыг боловсролын 1 хэсэг гэж Боловсролын яаманд аваачсан. Би бол их зөв бодлого болсон гэж бодож байгаа. Гэхдээ мэдээж

Эдийн засаг, хөгжлийн яам, Хөдөлмөрийн яам, Боловсролын яам хамтарч бол Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дээр бий болж байгаа ганцхан манай хөдөлмөрийн зах зээл дээр бий болж байгаа ийм сорилтууд биш шүү дээ. Дэлхий нийтээрээ хөдөлмөрийн зах зээл дээр маш их том сорилтууд бий болж байна. Хүн ам, насжилтууд их болж байна. Маш их том бодлогууд хийгдэж байна. Технологийн шилжилтүүд хийгдэж байна. Тэгэхээр бид нарын өмнө тулгамдаж байгаа том сорилтуудыг даван туулахад бас Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд бол урт хугацааны зөв бодлогыг мэргэжлийн боловсрол дээд боловсролтойгоо уяж байж л эндээс тодорхой шийдлүүд гарна гэж харж байгаа. Энэ хүрээндээ бид нар хөдөлмөрийн зах зээлийнхээ их өгөгдөлд суурилсан платформ, төлөвлөлтүүдийг бас хийдэг ийм цаг үе их ойрхон ирж байна гэдгийг бас би хэлэхийг хүсэж байна.

Тантай санал 1 байна. Боловсролд ер нь хүний хөгжил рүү хийж байгаа эх үүсвэрүүдийг бол ганцхан төсвийн эх үүсвэрээр бус уул уурхай АМНАТ гэж бид нар ярьж байгаа. Ингээд Ирээдүйн өв сан гэх мэтчилэнгээр Хуримтлалын сангаас бол тодорхой эх үүсвэрүүд зарцуулагдах ёстой. Тэгэхдээ хамгийн гол нь бид нар эхлээд мөнгөтэй болж байж л хуримтлал бий болно. Хуримтлал бий болж байж энэ хүний хөгжил, капитал руу хийх ёстой. Энэ чиглэл рүү бид нар Улсын Их Хурал дээр Засгийн газрын түвшинд бас бодлогын арга хэмжээнүүд авч байгаа гэдгийг та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа.

Тэгээд цаашдаа бол бид нар ЖДҮ-лэлийг дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангуудын .../минут дуусав/

Б.Мөнхсоёл: Болчихсон уу. Би бас асуулт асуучихъя. Ер нь бол энэ Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо гээд энэ хороог би бодохдоо яагаад байгуулсан бэ гэхээр нөгөө 2020, 2030 онд энэ зорилгын үзүүлэлтүүдийг биелүүлж үү, үгүй юу. Ядуурал тэглэгддэггүй юм гэхэд нэлээн эрчтэй буурсан уу, үгүй юу гээд улс орнууд амласан амлалтдаа хүрч үү, үгүй юу гээд дүгнэлт хийх болно. Тэрний төлөө үр дүнгээ ахиулахын тулд л ийм дэд хороо байгуулсан юм болов уу гэж бодоод байгаа юм. Тэгээд одоо ингээд шалгуур үзүүлэлтийнхээ дагуу үр дүндээ хэр хүрсэн бэ гээд яг харах гэхээр нэгдмэл тийм ойлгомжтой тодорхой зүйлс бас харагдахгүй байгаа. Энэ тал дээр асуулт асуумаар байна. Эдийн засаг, хөгжлийн яам бол базаж байгаа байх. Сайд бас хариулчих байх.

2 дугаарт нь халамжаас хөдөлмөр эрхлэлт рүү гээд нэлээн явсан. Тэр бодлогын үр дүн бас нэг их эрчтэй сайн харагдахгүй байх шиг байна. Тэр дээр тулгамдаж буй асуудлууд, нөгөө бүсчилсэн бодлоготойгоо холбогдуулаад хүний нөөцийн асуудал хэр байгаа вэ. Хэр бэлтгэгдэж байгаа вэ гэж асуумаар байгаа юм.

Ер нь ядуурал, зохистой хөдөлмөр эрхлэлт гээд маш том гүн, маш чухал утгатай үгс шүү дээ. Тэгээд Монгол даяар ер нь чухал асуудлууд жижүүрийн болоод яваад, уйтгартай асуудлууд болоод өнгөрөөгөөд байгаа нь надад маш харамсалтай санагддаг байхгүй юу. Тэгээд ядуурлыг бууруулах талаар яг дорвитой, бүр нэг үр дүнд хүрчихээр ямар бодлогыг та жишээлж хэлэх вэ сайдаа.

Л.Энх-Амгалан: Энэ их чухал дэд хороо байгаа юм аа Мөнхсоёл дарга аа. Та бас энэ хороог байнгын ажиллагаатай, энэ хороо дээрээ голлох хүний хөгжилтэй холбоотой тайлангуудыг авч хэлэлцдэг байх ёстой. Өмнө нь ч бас авч

хэлэлцэж байсан ийм сайн туршлагууд байгаа. Тэгэхээр энэ Засгийн газрын дэвшүүлж байгаа бодлого бол бид нар чинь хүний хөгжлийн индексийг 10 байраар ахиулна гээд нэг том зорилт тавьчихсан шүү дээ. Тэгээд хүний хөгжлийн байрыг одоогийн багаас 10 байраар ахиулна гэдэг бол бас тийм ч амар хийгдэх ажил биш. Гэхдээ ахиулах боломж бол байгаа.

Хүний хөгжлийн индекс яаж ахих юм бэ гэхээр мэдээж боловсролын түвшин, боловсролын хүртээмж, чанарын асуудлууд, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын асуудлууд, тэгээд мэдээж 1 хүнд ноогдох ДНБ. Энэ 3 үзүүлэлт л байгаа шүү дээ. Тэгэхээр энэ 3 үзүүлэлтүүдээр бас Хүний хөгжлийн тайлан гэж гардаг. НҮБ-д бид нар энэ тайлангаа хүргүүлдэг. Тэгэхээр энэ тайланг уг нь энэ хороон дээрээ их сайн хэлэлцэж баймаар байгаа юм Мөнхсоёл дарга аа. Хамгийн сүүлийн тайлангаа ч гэсэн энэ хороо дээр хэлэлцэж, энд холбогдож бүх яамнууд бас энэ тодорхой тавьж байсан үзүүлэлтүүд дээрээ аль дээр нь хүрсэн юм, аль дээр нь хүрээгүй юм. Яагаад хүрээгүй юм гэдэг зүйлийг энэ хороо дээр ярьж, энэ хорооноос бас тодорхой чиглэлүүд холбогдох байнгын хороонууд дээр өгдөг байвал их зүйтэй болов уу гэж бас би боддог юм.

Юуны хувьд бол энэ ядуурал халамжаас хөдөлмөр эрхлэлт гэсэн энэ том лоозон бол байсан. Бас бодлого тодорхой хэмжээгээр хэрэгжсэн. Огт хэрэгжээгүй биш. Гэхдээ цаашдаа бид нар ерөөсөө энэ халамжаас хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоо бол нэгхэн жилийн ийм зорилт, 1 Засгийн газрын зорилт биш. Ерөөсөө энийг бид нар тогтолцоо гэж харах ёстой. Үндэсний тогтолцоо болох ёстой. Тийм учраас бид нар энэ Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, Халамжийн тухай хуулиуд дээрээ тодорхой өөрчлөлт хийж, одоогийн байгаа манай яамны чиг үүрэг, манай яамны халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа агентлаг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаануудыг бид нар бүр тогтолцооны шинэчлэл хийхээс өөр сонголт байхгүй. Тэгээд энэ хүрээндээ бид нар энэ тогтолцооны шинэчлэлүүдийг бас хийх зайлшгүй шаардлага. Тэгэхдээ үүний эхний хүрээнд бол бид нар эрх зүйгээ, эрх зүйн шинэчлэлүүдээ хийж байж энэ тогтолцооны шинэчлэлүүдийг хийх ёстой.

Тэгээд Монгол Улс хэзээ ядууралгүй болох юм бэ гэхээр мэдээж эдийн засгийн өсөлт өндөртэй байж байж л энэ ядуурлаас гарна шүү дээ. ДНБ-ээ 10 мянган долларт хүрчихсэн улс орнуудад ядуурал гэдэг нэг ойлголтоос бас гардаг. Гэхдээ цаашдаа бид нар сүүлийн 30 жил ярьж байгаа ядуурлын ойлголтууд, ядуурлын статистик, тоон үзүүлэлтүүд, аргачлалуудаа дараагийн түвшинд гаргах 02 гэдэг энэ түвшинд гаргаж ирэх зайлшгүй ийм шаардлага байна гэж харж байгаа. Энэ хүрээндээ бид нар Үндэсний статистикийн газартай хамтарсан ажлын хэсгүүд, холбогдох яамдтай хамтарсан ажлын хэсгүүд бас ажиллаж байгаа. Ирэх жил бид нар энэ тайланг арай өөр хэлбэрээр өгдөг, өөр хэлбэрээр хардаг, өөр хэлбэрээр төлөвлөдөг, өөр хэлбэрээр хэрэгжүүлдэг ийм тогтолцоотой болчих болов уу л гэсэн хүлээлттэй байна.

Б.Мөнхсоёл: Эдийн засаг, хөгжлийн яамнаас нэмэлт хариулт байна уу. Эрдэнэбат 2 дугаар микрофон дээр оччих.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат. Манай яамны зүгээс улсын хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдийг ер нь үе шаттайгаар боловсруулаад явж байгаа. Тэгээд энэ дээр яг үндсэн гол хэмжих тоо маань үндсэн 2 том тоо яригдаж байгаа. Тэр 1 нь бол ядуурлыг 2 дахин

бууруулах, тэгээд 2024-2028 оны хооронд. Тухайлбал 2026 ондоо 5 функтээр бууруулах, нөгөөдөх нь 1 хүнд ноогдох ДНБ-ийг 10 мянган долларт хүргэх гээд. Тэгээд энэ бодлогын хүрээнд нөгөө дээрээс доош, доороос дээш зарчмын дагуу төлөвлөгөөнүүд маань хийгдээд явж байгаа. Та түрүүн асуусан нэг том энэ жилийн орж байгаа төсөл, арга хэмжээний тухайд гэвэл 150 мянган айлын орон сууц гээд. Энийг болохоор эрдэмтэн судлаачдын хийж байгаа тооцооллоор үйл ажиллагааны хөтөлбөрт орсон 149 төсөл хөтөлбөрүүдийг 1 бүрчлэн дүн шинжилгээ хийхэд ялангуяа орон нутагт хэрэгжих 150 мянган айлын орон сууц бол ядууралд хамгийн өндөр нөлөө импакт үзүүлэх юм байна гэж гарч ирсэн. Бид нар цаашид хийх ажлуудын 1 бол ойрын үед энэ намартаа Эс Ти Жи буюу энэ тогтвортой хөгжлийн хүрээнд НҮБ Юнискаптай хамтарч, бүс нутгийн арга хэмжээ хийнэ. Яагаад хийж байна гэхээр дэлхий даяар ялангуяа манай бүс нутагт, тэр тусмаа манай Монгол улс ч гэсэндээ тогтвортой хөгжлийн зорилтууд дээр хоцрогдолтой явж байгаа. Тэгээд энэ нь болохоор нэг яамны ажил биш, бид бүгдийн ажил учраас бүс нутгийн хурлыг Монгол Улсад зохион байгуулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд бол бэлтгэл ажил болон энэ хурлын хэлэлцүүлгийн үеэр бол нэлээд бас шийдлүүд хоорондоо ярилцаж, асуудлыг нэг талд гарахад алхам болох бай гэж бодож байна. Баярлалаа.

Б.Мөнхсоёл: Баярлалаа. Би зүгээр нэмж хэлэхэд Энх-Амгалан сайдаас өмнө бас Гантөмөр сайд танилцуулга хийсэн юм Энх-Амгалан сайд аа. Тэгээд дараалаад яам, яамдаа, ялангуяа энэ Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлт дээр шууд холбогдож ажилладаг яамдаасаа сонсгол хийгээд байгаа юм.

Тэгээд 1 харамсаад байгаа юм нь энэ Дэд хорооны хурал дээр хангалттай гишүүн байхгүй шүү дээ. 10 гишүүнтэй угаасаа. 10-ын 5, 6 нь оролцоод байхаар тайлан тавьж байгаа хүмүүс, асуултад хариулж байгаа мэргэжилтнүүд нь олон байгаад байдаг. Сонсож байгаа нь цөөн байхаар харамсалтай санагдаад байгаа юм. Тэгээд ярьж байна л даа. Эдийн засгийн байнгын хороо руу бас энэ том том тайлан хэлэлцсэнээ оруулаад, энэ тайлангаа хуваалцаад байгаа Эдийн засгийн байнгын хороон дээрээ. Орж ирж ирэх оролцох нь оролцоорой гээд хэлчихдэг байхгүй юу. Мэдээлэл өгчихдөг шүү. Тэгээд цаашаа бас албан ёсоор бас дахин хэлэлцэх ийм хүсэлтэй байна. Би сая референтдээ бас хэлчихлээ.

Асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу. Үг хэлэх гишүүд Бадамсүрэн гишүүн байна.

М.Бадамсүрэн: Манай энэ Дэд хорооноос энэ хүний хөгжил, боловсролд оруулах хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлэх талаар ийм тодорхой албан шийдвэр гаргаасай л гэж би бол хүсэж байгаа юм. Мөнгөтэй болоод, мөнгөтэй болсны дараа хүндээ хөрөнгө оруулна гэвэл бидний хөгжил улам л хойшлох гээд байгаа юм л даа. Тийм учраас зүгээр бусад улс орнуудын түүхийг хараад байхад эрдэм боловсролтой, тэгээд ялангуяа технологи шингээсэн ийм зүйл хийсэн газар л хөгжөөд байгаа юм л даа. Байгалийн баялаггүй Өмнөд Солонгос, Япон гэдэг юм уу тийм. Тэгэхээр энэ дээр миний хэлэх гээд байгаа санаа бол энэ төсвийн ДНБ-д эзэлж байгаа хувь хэмжээ гээд нэг ийм босго тогтоож өгмөөр байгаа юм. Тэгэхгүй болохоор яг ингээд хараад байхад тухайн үеийн тэр Сангийн яам байдаг юм уу, тэр төсвийн захирагч хэлэлцүүлгийн шатад юм уу ерөөсөө энийгээ хойшлуулчихаад байгаа байхгүй юу яг бодит байдал дээр. Тэгээд зоригтой л энийг яг энэ хүнийхээ хөгжилд оруулах юмаа л нэмэгдүүлэхгүй л бол тэгээд бусад юмаа яадаг юм, хөрөнгө оруулалтын зарим ажлуудаа больж болно шүү дээ. Зарим шаардлагагүй

юмнуудыг. Тэгээд зарим юмнуудыг бол больж болно шүү дээ. Тэр чинь маш том үнийн дүнтэй тэгээд яг үнэндээ тэр дээр 1 компани олоод л нэлээн өндөр хэмжээний ашиг олоод, тэгээд л энэ чинь өөрөө эргээд эдийн засгийн үр өгөөжөө өгч чадахгүй байгаа шүү дээ. Тэгээд яг яривал зөндөө л ярих юм байна л даа. Жишээлбэл зарим аймагт бүх сумдаа засмалаар холбочихсон. Тэр ямар эдийн засгийн үр өгөөж байгаа юм. Тэгэхэд боомт чиглэлийн зам төмөр замуудаа холбож чадаагүй л байгаа шүү дээ. Яг л ийм тогтолцоогоор явж ирсэн шүү дээ. Яг ингээд мөнгө байхгүй гээд үзэх юм бол мөнгө зөндөө байгаа шүү дээ. Тэр олон сумдыг холбосон засмал зам байдаг юм уу. Тэр бусад юунд оруулсан хөрөнгө бол аймшигтай юм байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг л тэр ялангуяа нөхөн сэргээгдэхгүй уул уурхайн баялгаас орж байгаа мөнгөнөөс нөхөн сэргээгдэх энэ салбар луу оруулах тэр тогтолцоог нь оновчтой бүрдүүлж өгөөд цаашдаа явчихвал энэ бол шал өөр болно гэж би хувьдаа бодож байгаа. Олон ч судалгаа энийг харуулдаг. Тэгэхгүй бид нар байхгүй гэдэг юм уу, эсвэл төсвөө алдагдалтай батлаад ингээ гэдэг юм уу, эсвэл мөнгө нь хүрэхгүй байгаа юм чинь гээд байвал хэзээ ч байж чадахгүй. Хүн байгаа гэвэл нөгөө юу гэдэг билээ. Өөрөө байгаагаа өгье гэвэл ганцаасаа гэдэг шиг тэгээд байгаа гэвэл болно.

Би яагаад энэнд итгэлтэй байна гэхээр хий хоосон тийм поп юм яриагүй. Би бол Дорнод аймгийн Засаг даргаар 9 жил ажилласан. Бид 300 бага ангийн багштай Дорнод аймаг бид нар 10 жилд бүх багшийг орон сууцтай болгоно гэж зорилт тавиад, жилд 30 багшид 20 сая төгрөг бид нар өгч байгаа. 30 багшид. Яах вэ тэр бол манай уул уурхайгаас орон нутгийн өөрийнх нь хамтын ажиллагааны гэрээнээс орсон орлогоо бид нар зоригтой зарцуулж байгаа юм. Олон хүн надад энийг наадхаар чинь цэцэрлэгт хүрээлэн барья. Та өөрийнхөө нэрээр нэрлэгдсэн гоё юм барьчаа гэж хэлдэг. Би үгүй гэж хэлдэг. Энэ чинь бага ангийн бүх багшаар дамжаад бүх хүүхэд сургуульд сурна. Тэр багшаар дамжаад энэ баялгийн өгөөж чинь бүх айлд очиж байгаа л байхгүй юу. Тэгээд 5 жилийн дараа, 10 жилийн дараа Дорнодын хүүхдүүд зүгээр л Монгол Улсад бүх салбартаа тэргүүлнэ. Би энийг баталгаатай хэлнэ. Тэгэхдээ энэ хугацаа урт орно. Тэгэхээр байгаа гэвэл бид нарт байлгая гэвэл юм байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ рүү зоригтой өөрчлөлт хийе. Энэ дээр нь дуу хоолойгоо гаргая. Манай бодлогын хороо энэ дээр нь тодорхой шийдвэр гаргаж өгөөч ээ л гэдэг ийм л хүсэлтэй байгаа юм. Тэгвэл өнөөдрийн хурлын үр дүн гарна гэж бодож байна.

Б.Мөнхсоёл: Үг хэлж дууслаа. Тэгээд миний хувьд бол энэ зэргийн асуудлуудыг бас олон сайд нар байхад хэлэх ёстой байх. Бид нар зөвхөн энэ дэд хороо дээр биш, Эдийн засгийн байнгын хороо дээр цаашлаад чуулган дээр хэлэх хэрэгтэй. Тэгж байж 10 гишүүний тал нь байгаа дэд хорооноос биш том том Байнгын хороод чуулган дээр анхаарлын төвд энэ асуудлуудаа аваачиж, тэгээд Энх-Амгалан сайдын хэлээд байгаа шиг төсөв мөнгийг нь ч гэсэн зөв хуваарилж байх ёстой. Тэгээд төсөв, санхүүгийн асуудал дээр маш олон цэгцлэх зүйлүүд байгаа шүү дээ. Би өөрөө төсөв цаглавар ажлын хэсэгт байгаа. Урсгал зардлыг цэгцлэх, тэгээд хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх, яг чухлаас нь чухал биш рүүгээ орох, зөвхөн цемент цутгаад байхгүй хүний хөгжилдөө анхаарах, энэ улсыг авч явах нь хүний нөөц, хүн, хүний чадамж мөн юм бол цалин пүнлүүг нь нэмэх, чадамжтай хүмүүсээ зөв газарт нь байрлуулдаг байх, улс төржихөөс багасгах, ялсан нам нь хүмүүсээрээ дүүргэдгээ болих гээд ярьсаар байгаад олон жил болоод ухарсаар байгаа гэж би хардаг.

Ерөөсөө дэвшил биш ухралт явж байгаа. Тэгээд бидний хүч хүрэх юм уу, үгүй юм уу ямар ч байсан дор дороо чанартайгаар ажлаа хийх ёстой байх. Одоогоор харахад улс төр бас л их хэвээрээ л байна шүү дээ.

Ингээд үг хэлж дуу дууслаа. Өнөөдрийн Ядуурал, зохистой хөдөлмөрийн зорилгын хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээллийг хэлэлцэж дууслаа.

Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны өнөөдөр хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон Энх-Амгалан сайд, гишүүд, ажлын хэсэгтээ баярлалаа.

13.38 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ